

Монгол Улс дахь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх төсөл (DPUB 2)
2022 он 5-р сарын 19

Гурав дахь удаагийн “Ажлын байрны дадлагажуулагчийн талаарх
анхан шатны семинар”-ын удирдамж

DPUB 2 төслийн зүгээс 2022 оны 6-р сарын 16, 17-нд 3 дахь удаагийн “Ажлын байрны дадлагажуулагчийн талаарх анхан шатны семинар”-ыг дараах агуулгын дагуу зохион байгуулна. Семинарын оролцогчид цаашид “Ажлын байрны дадлагажуулагчийн хөдөлмөр эрхлэлтэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ”-тэй холбоотой Загвар төслийн үйл ажиллагаанд оролцоно. Мөн ажлын байрны дадлагажуулагчийг бэлтгэх сургагч багшаар ажиллах хүмүүсийг семинарын оролцогчдын дундаас сонгохоор төлөвлөж байна. Иймд семинарын дараа төслийн цаашдын үйл ажиллагаанд идэвх зүтгэлтэй оролцох хүсэлтэй хүмүүсийг бүртгэж, сонгон шалгаруулна.

1. Хугацаа

6-р сарын 16 (Пүрэв), 17 (Баасан) – 2 өдөр

2. Зохион байгуулагдах газар

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн 1-р давхрын хурлын танхим

3. Зорилго

“Ажлын байрны дадлагажуулагч” гэдэг нь ХБИ-ийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллуулахын тулд ААНБ, ХБИ-ийг холбох үүргийг гүйцэтгэж, аль алинд нь шууд дэмжлэг үзүүлэх мэргэшсэн ажилтан юм. Тус семинараар дамжуулан ажлын байрны дадлагажуулагчийн гүйцэтгэх үүргийн талаар ойлголт өгөх, семинарын дараа Ажлын байрны дадлагажуулагчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний Загвар төсөлд биечлэн оролцох хүний нөөцийг бэлтгэнэ.

4. Хөтөлбөр

6-р сарын 16 (Пүрэв)	Лекцийн сэдэв	Агуулга
8:30	Бүртгэл	
9:00-9:30	Нээлт	<ul style="list-style-type: none"> • ХНХЯ • DPUB2 төсөл
9:30-9:45	Төслийн үйл ажиллагааны танилцуулга	
9:45-10:15	Семинарын танилцуулга	<ul style="list-style-type: none"> • Сургалтын ерөнхий явц, анхаарах зүйлс • Багш нарын танилцуулга • Оролцогчид өөрсдийгөө танилцуулах
10:15-10:30	Завсарлага	
10:30-11:15	Лекц 1: Огава багш	<ul style="list-style-type: none"> • Японы ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоо болон холбогдох



	“Хөдөлмөр эрхлэлтэд дэмжлэг үзүүлэх ерөнхий үйл явц, ажлын байрны дадлагажуулагчийн үйл ажиллагааны чиг үүрэг”	байгууллагуудын тухай • Японы ажлын байрны дадлагажуулагчийн тогтолцоо • Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлын байрны дадлагажуулагчийн үүрэг
11:15-12:25	Лекц 2: Сакаи багш “Үнэлгээ хийх, тохирсон ажилд оруулах” *Асуулт хариулт	• Ажлын байрны дадлагажуулагчийн дэмжлэгийн хүрээн дэх үнэлгээний талаарх ойлголт • ХБИ болон ажлын байранд хийх үнэлгээний онол, арга зүй • Үнэлгээ хийснээр тохирсон ажилд оруулж чадсан жишээ
12:25-13:30	Өдрийн хоол	
13:30-14:40	Лекц 3: Инаба багш “Ажлын байран дахь төвлөрсөн дэмжлэг” *Асуулт хариулт	• Ажлын байрны дадлагажуулагчийн төвлөрсөн дэмжлэгийн агуулга, анхаарах шаардлагатай гол зүйлс • Ажлын байрны дадлагажуулагчийн үүргийг тодорхойлох, төлөвлөгөөт дэмжлэгийн хэрэгцээ шаардлага • Бие дааж ажиллахад чиглэсэн дэмжлэг (ойлгомжтой заах арга, туслах хэрэглэгдэхүүн, тавигдах шаардлага)
14:40-14:55	Завсарлага	
14:55-16:05	Лекц 4: Тамаширо багш “Фэдинг (дэмжлэгээ аажмаар багасгах) болон үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлэх тухай” *Асуулт хариулт	• Натурал дэмжлэг (хамт олны зүгээс үзүүлэх дэмжлэг)-ийг бий болгох • Фэдинг (дэмжлэгээ аажмаар багасгах)-ийн хэмжээ, чанар, арга зүй • Хөдөлмөр эрхлэлтийг тогтворжуулах дэмжлэгтэй холбоотой анхаарах зүйлс
16:05-16:40	Эхний өдрийн семинарын дүгнэлт	
6-р сарын 17 (Баасан)	Лекцийн сэдэв	Агуулга
8:30	Бүртгэл	
9:00-9:15	2 дахь өдрийн семинарын танилцуулга	• 2 дахь өдрийн хөтөлбөрийн товч агуулга • "Дүрд орж тоглох" дасгал ажлын үед анхаарах зүйлс



9:15-10:00	Лекц 1: Сакаи багш “ААНБ-уудад нөлөөлөх” *Асуулт хариулт	<ul style="list-style-type: none"> • Яагаад ААНБ-ууд ХБИ-ийг ажилд авдаг вэ? • ААНБ-уудтай хамтран ажиллах арга зам • ААНБ-уудад тулгарч буй асуудал, бэрхшээл, шаардлагатай дэмжлэг? • Жижиг, дунд болон томоохон ААНБ-ын ялгаа, хүний нөөцийн менежментийн тогтолцоо • Ажлын байрны дадлагажуулагчийн хэрэгжүүлэх дэмжлэгийн хэрэгцээ, түүнийг тайлбарлах арга • ААНБ-тай холбогдохоос эхлээд ажилд орох хүртэлх үйл явц • Уулзалтын зорилго, явц, төгсгөл, бизнесийн ёс зүй • Холбогдох материалыг бэлтгэх
10:00-10:15	Завсарлага	
10:15-10:35	Дүрд орж тоглох дасгал ажлын талаар тайлбарлах	
10:35-12:15	Дүрд орж тоглох дасгал ажил: "ААНБ-уудтай уулзалт хийх"	<ul style="list-style-type: none"> • ААНБ дээр очиж уулзалт хийх бэлтгэл - 25 мин • 3,3-аараа хуваагдаж 1 компани болох – 20 мин х 2 компани • Хэлэлцүүлэг - 20 мин • Илтгэл - 10 мин • Дүгнэлт - 5 мин
12:15-13:15	Өдрийн хоол	
13:15-14:15	Лекц 2: Инаба багш “Ойлгомжтой заах арга барил” *Асуулт хариулт	<ul style="list-style-type: none"> • Системчилсэн зааварчилгааны талаарх ойлголт, хэрэглээний хамрах хүрээ • Системчилсэн зааварчилгааны хүчин зүйлс • Ажил үүрэгт дүн шинжилгээ хийх тухай ойлголт, хийх ажлын дарааллыг боловсруулах үед анхаарах зүйлс, бодит жишээ
14:15-14:35	Дүрд орж тоглох дасгал ажлын талаар тайлбарлах	
14:35-14:50	Завсарлага	
14:50-16:50	Дүрд орж тоглох дасгал ажил: "Ойлгомжтой заах арга барил"	<ul style="list-style-type: none"> • Ажил үүргийн дүн шинжилгээг боловсруулах, багаараа дүгнэлт хийх - 30 мин • Ширээн дээрхээ цэгцэлж, бэлтгэх - 5 мин • Дүрд орж тоглох дасгал ажил – 7 мин х 6 хүн=42мин • Хэлэлцүүлэг -25 мин • Илтгэл - 10 мин • Дүгнэлт - 8 мин
16:50-17:20	Ажлын байрны дадлагажуулагчийн үйл ажиллагааг зохицуулах	



	удирдамжийн танилцуулга	
17:20-17:50	2 өдрийн дүгнэлт Гэрчилгээ гардуулах Хаалт Дурсгалын зураг	<ul style="list-style-type: none"> • Япон мэргэжилтэн • ХНХЯ • DPUB2 төсөл

5. Оролцогчид

Нийт 48 хүн. Семинар дууссаны дараа ажлын байрны дадлагажуулагчийн хөдөлмөр эрхлэлтэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээний чиглэлээр ажиллах хувийн хэвшлийн хөдөлмөрийн биржүүд, ХБИ болон ААНБ-д дэмжлэг үзүүлэх ТББ, хувийн хэвшлийн ААНБ-ын төлөөллийг оролцуулна. Дэлгэрэнгүйг дараах хүснэгтээс харна уу.

Харьяа байгууллага	Хүний тоо
Хувийн хэвшлийн хөдөлмөрийн биржүүд	30 хүн
ТББ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжигч байгууллага	10 хүн
ААНБ	8 хүн

6. Оролцогчдод тавигдах шаардлага

- 1) 2 өдрийн семинарын хөтөлбөрт бүрэн хамрагдах боломжтой байх. Хэсэгчилж оролцох, онлайнаар хамрагдахыг зөвшөөрөхгүй (**заавал**) .
- 2) Тус семинар болон цаашид DPUB 2 төслийн хэрэгжүүлэх “Загвар төсөл”-ийн үйл ажиллагаанд оролцох зөвшөөрлийг харьяа байгууллага, удирдлагаасаа авсан байх (**заавал**) .
- 3) ХБИ, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 1-ээс дээш жил ажилласан туршлагатай байх (**заавал**). Тус салбарт 5-аас дээш жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр тодорхой үр дүн гарган ажиллаж буй ТББ, ХБИ-ийг 3-аас дээш жил тогтвортой ажиллуулж буй ААНБ-уудад давуу тал олгоно.
- 4) Тус төслөөс 2021 онд зохион байгуулсан “Дэмжлэгтэй хөдөлмөр эрхлэлтийн талаарх семинар”, “Ажлын байрны дадлагажуулагчийн талаар үндсэн ойлголт өгөх суурь сургалт”, “Дэмжлэгтэй хөдөлмөр эрхлэлтийн загварт суурилсан ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоо ба үр дүн” сэдэвт зайн сургалтад хамрагдсан хүмүүст давуу тал олгоно.

7. Сонгон шалгаруулалт

(ТББ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжигч байгууллага, хувийн хэвшлийн ААНБ-уудад хамаарна)

Шалгаруулалт хийх арга, хуваарь

- Материал хүлээж авах эцсийн хугацаа: 5/30 (Даваа), 17:00 цаг хүртэл



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ



- Материалын шалгаруулалт: 6/2-8 (Жич: Бүртгүүлсэн хүмүүсийн тоо их байх тохиолдолд онлайнаар ярилцлагын шалгаруулалт хийнэ.)
- Шалгаруулалтын хариуг мэдэгдэх: 6/9 (Пүрэв)

Хэрхэн бүртгүүлэх тухай

Доорх линкээр орж, шаардлагатай мэдээллүүдийг **5/30 (Даваа)-ны 17:00 цагаас өмнө** бөглөж илгээнэ үү. Хугацаа хэтэрсэн материалыг хүлээн авахгүй.

Бүртэлийн линк: <https://forms.gle/Xa9NTgQ9YhgCtUJdA>

Тодруулах зүйл байвал доорх хаягаар холбоо барина уу.

- Имэйл хаяг: dpub.jica@gmail.com
- Гар утас: 9401-6406 (төслийн ажилтан Г.Амаржаргал)
9401-6402 (төслийн ажилтан Х.Энхжин)